

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ХӨТӨЛБӨРИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

2023.12.28

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Монгол Улсын Их Хурлын 2020 оны “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 24, Засгийн газрын 2020 оны “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” 203 дугаар тогтоолд тусгагдсан Биеийн тамир, спортын салбарт хамаарах арга хэмжээний 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтийг тухайн онд тавьсан зорилт, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлттэй харьцуулан тооцож, үр дүнг үнэлэн, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулж, удирдлагыг үнэн бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үндэслэл, үнэлгээний арга зүй

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны “Журам шинэчлэн батлах тухай” 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан салбарын зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн 2022 оны жилийн эцсийн тайлан ажлын бодит үр дүнг, хүрэх түвшинтэй харьцуулан биелэлтийг хувиар тодорхойлж, зорилтын хэрэгжилтийг дараах ангилалд шилжүүлэн тооцлоо. Үүнд:

- “үр дүнтэй” 100 хувь;
- “тодорхой үр дүнд хүрсэн” 70 – 100 хүртэл хувь;
- “эрчимжүүлэх шаардлагатай” 30 – 70 хүртэл хувь;
- “үр дүнгүй” 0- 30% үнэлгээг гаргалаа.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Биеийн тамир, спортын салбарын 3 зорилт 16 арга хэмжээний хэрэгжилтийн 2022 оны тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэлээ.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөгөөний шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин 2023 оны жилийн эцэст зорилтын дундаж 53.1 хувьтай, буюу “Эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлэгдэж байна.

## Хүснэгт 1. Зорилтын дундаж үр дүн

№	Дэс тугаар	Зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн хувь
<b>ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>			
2.2.1. Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог үндэсний хэмжээнд бүрдүүлнэ.			<b>86%</b>
1.	1.1.	Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилын үр дүнд заавал биелүүлэх норм, нормативыг насны ангиллаар тогтоож, мөрдүүлэх, насны бүлэг, ажил, амьдралын онцлогт нийцсэн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.	100%
	1.2.	Сумдад орон тооны биеийн тамирын арга зүйчийг үе шаттай ажиллуулж эхлүүлнэ.	90%
	1.3.	Биеийн тамир, спортын салбарын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах мэдээллийн технологийн бааз, платформ бий болгож хэрэгжүүлнэ.	70%
	1.4.	Биеийн тамир, спортын чиглэлд төрийн зарим чиг үүргийг гэрээний дагуу төрийн бус байгууллагад шилжүүлэн дэмжлэг үзүүлж, ажлын байр бий болгоно.	100%
	1.5.	Үндэсний шигшээ багийн залгамж халааг сайжруулах, тив, дэлхийн түвшинд өрсөлдөх Залуучуудын шигшээ багийн спортын төрлийг нэмэгдүүлнэ.	70%
2.2.2. Монгол үндэсний уламжлалт спортыг дэлхий нийтэд таниулахад төрөөс бодлогоор дэмжиж, үндэсний спортын төв байгуулж, гадаад улсын баг тамирчдыг оролцуулах тэмцээн, наадмын тогтолцоог хөгжүүлнэ.			<b>43.3%</b>
2.	2.1.	Бөх, сурын харваа, шагайн харваа, морин болон тэмээн пөлогийн спортын төв байгуулах, үндэсний багтай болно.	0%
	2.2.	Улсын хэмжээнд иргэдийн дунд нийтийн спортын төрөлжсөн наадмыг 2-4 жил тутамд зохион байгуулна.	100%
	2.3.	Үндэсний уламжлалт спортоор олон улсын спортын наадмын брэнд бий болгоно.	30%
2.2.3. Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцсэн спортын барилга байгууламжийг барина			<b>30%</b>
3.	3.1.	Тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, наадмыг зохион байгуулах шаардлага хангасан, олон улсын жишигт нийцсэн 30.000-40.000 хүний суудалтай цэнгэлдэх хүрээлэн барьж ашиглалтад оруулна.	0%
	3.2.	Спортын төв ордон барих ажлыг эхлүүлнэ.	0%
	3.3.	Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тусгай тоноглол бүхий спорт цогцолбор байгуулна.	0%
	3.4.	Нийслэлийн спортын сургалттай дунд сургуулийн барилгыг барьж ашиглалтад оруулна.	0%
	3.5.	Нийслэлийн болон Налайх, Баянзүрх, Баянгол, Сүхбаатар дүүргийн иргэдэд үйлчлэх усан бассейн бүхий спортын цогцолборын ажлыг үргэлжлүүлэн ашиглалтад оруулна.	90%
	3.6.	Говь-сүмбэр, Дундговь, Сүхбаатар аймагт шинээр спортын цогцолбор барина.	90%
	3.7.	Захиалгын дагуу барилга байгууламжийн нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төсөл боловсруулах ажлыг зохион байгуулна.	30%
<b>Зорилтын дундаж үнэлгээ</b>			<b>53.1</b>

Дөрөв. Дүгнэлт.

Зорилт 2.2.2 Монгол үндэсний уламжлалт спортыг дэлхий нийтэд таниулахад төрөөс бодлогоор дэмжиж, үндэсний спортын төв байгуулж, гадаад улсын баг тамирчдыг оролцуулах тэмцээн, наадмын тогтолцоог хөгжүүлнэ.

Арга хэмжээ 2.1. “Бөх, сурын харваа, шагайн харваа, морин болон тэмээн пөлогийн спортын төв байгуулах, үндэсний багтай болно” Үндэсний багтай болоход морин уралдаан, жороо морь, ширээний шагай, халх сурын харваа, бариуд сурын харваа, морин харваа, уран уургач, эмнэг сургагч, тэмээн поло спортын холбоод зураг төслийн даалгаварт тусгуулах санал, зураг төслийн даалгаварт тусгуулах талбайн стандартын хэмжээ, ерөнхий төлөвлөлтийн зургийн талаарх мэдээлэл боловсруулах ажил хийгдэж байгаа боловч 2023 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээ тусгах боломжгүй.

Арга хэмжээ 2.3. Үндэсний уламжлалт спортоор олон улсын спортын наадмын брэнд бий болгоно. Олон улсын үндэсний спортын наадмын үзэл баримтлалын боловсруулагдсан төсөл шаардсан боловч нотлох баримт бичиг ирүүлээгүй болно.

Зорилт 2.2.3 Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцсэн спортын барилга байгууламжийг барих.

Арга хэмжээ 3.1. Тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, наадмыг зохион байгуулах шаардлага хангасан, олон улсын жишигт нийцсэн 30.000-40.000 хүний суудалтай цэнгэлдэх хүрээлэн барьж ашиглалтад оруулна. /Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 315 дугаартай “Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн байгуулах талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 3 дахь заалтад “Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэнгийн төслийн иж бүрэн ажлын зураг төслийг боловсруулах, богино хугацаанд барьж байгуулан ашиглалтад оруулах асуудлыг хариуцан зохион байгуулж, шаардагдах хөрөнгийг /Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид” тусгайлан даалгасан/

Арга хэмжээ 3.2. Спортын төв ордныг барих ажлыг эхлүүлэхэд эхлүүлэхэд БНХАУ-ын буцалтгүй тусламжаар шинэчлэн барих санхүүжилтийн эх үүсвэр үйл ажиллагаа 2 улсын хамтын ажиллагаатай салшгүй холбоотой тул эрчимжүүлэхэд хүндрэл учруулж байна.

Арга хэмжээ 3.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тусгай тоноглол бүхий спорт цогцолбор байгуулна. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спорт цогцолбор” барих газрыг Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/112 дугаар захирамжаар Хан-Уул дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах 10 га газрын эзэмших эрхийн гэрчилгээг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд 15 жилийн хугацаатай олгосон /Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам/

Арга хэмжээ 3.4. Нийслэлийн спортын сургалттай дунд сургуулийн барилгыг барьж ашиглалтад оруулна. Монгол Улсын 2022 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын тухай хуулийн 2 дугаар хавсралтад Боловсрол, шинжлэх ухааны сайдын

2022 оны төсвийн жилд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтын XIII.1.1.31-т “Спортын төрөлжсөн сургуулийн барилга /640 суудал, Төв, Зуунмод сум/” 2019 оноос хойш баригдаж 2022 онд дуусахаар төлөвлөгдсөн байна. /Боловсрол, шинжлэх ухааны сайд/

Арга хэмжээ 3.8. Захиалгын дагуу барилга байгууламжийн нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах холбогдох судалгааг эрчимжүүлж ажиллах.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн 2.2.2 дүгээр зорилтын 1 дэх арга хэмжээ “Бөх, сурын харваа, шагайн харваа, морин болон тэмээн пөлогийн спортын төв байгуулах, үндэсний багтай болно.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн 2.2.3 дүгээр зорилтын 1, 2, 3, 4 дэх арга хэмжээг үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээнүүд манай байгууллагаас тус тус үл хамаарч байна.

2022 оны жилийн эцсийн хэрэгжилтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн 2.2.2 дүгээр зорилтын 2.1 дэх арга хэмжээ, 2.2.3 дугаар зорилтын 3.1, 3.3, 3.4 дэх арга хэмжээнүүд манай байгууллагаас хамааралгүй байгаа тул программаас хасах саналыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс Засгийн газрын Хэрэг Эрхлэх газарт хүргүүлсэн болно.

Байгууллагын 2022 оны жилийн эцсийн тайланд цаашид Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт 2.2.3.1, 2.2.3.3, 2.2.3.4 тайлангийн хэрэгжилтэд хүндрэл учруулж улмаар эцсийн үр дүнд сөргөөр нөлөөлөхөөр дүгнэгдэж байгааг холбогдох газар, хэлтэст хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс тайланг хүргүүлсэн боловч тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Тав. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ / зөвлөмж /

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн 2.2.3 дүгээр зорилтын 8 дэх арга хэмжээний Захиалгын дагуу барилга байгууламжийн нэг маягийн болон давтан хэрэглэх зургийг орчин үеийн стандартад шинэчлэн боловсруулах ажил үр дүнгүй болон эрчимжүүлэхийг Бодлого, төлөвлөлтийн газар.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн 2.2.2 дугаар зорилтын 3 дэх арга хэмжээний Үндэсний уламжлалт спортоор олон улсын спортын наадмын брэнд бий болгох ажлыг Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтэс анхаарч ажиллах.

Цаашид удирдлага, зохион байгуулалт, хамтын ажиллагааг сайжруулах 2.2.3.1, 2.2.3.3, 2.2.3.4 арга хэмжээнд холбогдох ажлын чиглэлээр байгууллага хоорондын арга хэмжээг тодорхой болгож шийдвэрлүүлэхийг Бодлого, төлөвлөлтийн газар.

Санхүүжилтийн асуудлаас шийдвэрлэгдээгүй 2.2.2.1, 2.2.3.2 арга хэмжээнүүд удааширсан улмаас хүндрэл учруулж эцсийн үр дүнд сөргөөр нөлөөлж байгаа тул Төрийн, захиргааны удирдлагын газар, Бодлого, төлөвлөлтийн газар, Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтэс тус тус 2024 оны төлөвлөгөөнд тодорхой арга хэмжээ тусгаж төлөвлөн ажиллахыг зөвлөмж болгож байна.

ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:  
ХШУДАХ-ИЙН ДАРГА



Н.БАТСҮХ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:  
ХШУДАХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



О.БОЛОРМАА